



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

“Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.9, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3.3.1, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн А-1/235 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК-ийн нийтэд санал болгон гаргах 24-36 сарын хугацаатай, жилийн 10 хүртэлх хувийн хүүтэй нэг бүр нь 100,000.0 /нэг зуун мянга/ төгрөг, 6.8 хүртэлх хувийн хүүтэй нэг бүр нь 100.0 /нэг зуу/ ам долларын нэрлэсэн үнэ бүхий нийт 20,000,000.0 /хорин сая/ хүртэлх ширхэг өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/-д үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д зөвшөөрсүгэй.

2. Нийтэд санал болгон гаргахыг зөвшөөрсөн өрийн хэрэгслийг үе шаттайгаар гаргах хугацаа, үндсэн болон хүүгийн төлбөр төлөх хуваарийн талаарх мэдээллийг Хороонд тухай бүр мэдэгдэж, анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл авахыг “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК /Б.Ганхуяг/, “Би Ди Сек ҮЦК” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын 2-д заасны дагуу өрийн хэрэгслийг үе шаттайгаар гаргаж, шаардлагатай хөрөнгийг татан төвлөрүүлсэн тохиолдолд Хорооноос үнэт цаасны анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцож хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тухай бүр олгохыг “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК /Б.Ганхуяг/-д мэдэгдсүгэй.

4. Нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг үе шаттайгаар гаргахад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.16-д заасан зөвшөөрлийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авахыг “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК /Б.Ганхуяг/-д даалгасугай.

5. Өрийн хэрэгслийг үе шаттайгаар нийтэд санал болгон гаргаж, Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай явагдсанд тооцох хүртэлх хугацаанд арилжаанаас олсон орлогыг тухай бүр тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д үүрэг болгосугай.

6. Тогтоосон хугацаанд үе шаттайгаар гаргаж буй өрийн хэрэгслийн арилжааны тайланг анхдагч зах зээлийн арилжаа дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан тус Хороонд ирүүлж, үндсэн болон хүүгийн төлбөрийг тухай бүр төлж хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ

биелүүлэн, үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад заасны дагуу зарцуулж, улирал тутам холбогдох тайланг Хороонд ирүүлэхийг “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК /Б.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

7. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан хугацаанд өрийн хэрэгслийг олон нийтэд танилцуулж, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулж чадаагүй нөхцөлд Хороонд тухай бүр мэдэгдэж, хугацааг сунгуулах зөвшөөрөл авахыг “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК /Б.Ганхуяг/, “Би Ди Сек ҮЦК” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

8. Энэхүү тогтоолын 7-д заасан хугацаанд өрийн хэрэгслийг олон нийтэд танилцуулж, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулан, үнэт цаасны танилцуулгад заасан хөрөнгийг татан төвлөрүүлж чадаагүй нөхцөлд Хорооноос зарагдаагүй үлдсэн өрийн хэрэгслийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасахыг “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК /Б.Ганхуяг/, “Би Ди Сек ҮЦК” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус мэдэгдсүгэй.


9. Нийтэд санал болгон нээлттэй хэлбэрээр татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9-д заасны дагуу Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Монгол улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан, техник эдийн засгийн үзүүлэлтийн тооцоолол, байгаль орчны нөлөөллийн шинжилгээ бүрэн хийгдсэн, үр ашигтай төслүүдэд тэргүүн ээлжинд зарцуулах чиглэлийг баримталж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК /Б.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

10. Өрийн хэрэгслийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК, Хяналт шалгалт, зохицуулалтын газар /Б.Долгорсүрэн/-г тус тус даалгасугай.

11. Үе шаттайгаар олон нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөгдөх хугацааг үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссан өдрөөс тооцох ба үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд зохих журмын дагуу холбогдох арга хэмжээ авч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж ажиллахыг “Би Ди Сек ҮЦК” ХК /Д.Даянбилгүүн/, “Эрдэнэс-Тавантолгой” хаалттай ХК /Б.Ганхуяг/-д тус тус үүрэг болгосугай.

12. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН